



САНГИЙН САЙД Ч.УЛААН  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 129 УАТ-САТ БОСЖМА - ИОУИТ

Зөрчил арилгах тухай

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад Орон сууц санхүүжилтийн корпорацитай хийх тооцоог нэр, данс зөрүүтэй тусгасан зөрчил илэрлээ.

Тухайлбал, Орон сууцны санхүүжилтийн корпорациас авах бондын авлагын 2010 оны үлдэгдэл 80.0 тэрбум төгрөгийг Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд нэр бүхий арилжааны 3 банкнаас авах авлагаар, 2011 онд үүссэн бондын авлагын 72.0 тэрбум төгрөгийг авлагын дансанд ОССК-иас авах авлагаар тус тус бүртгэсэн нь УСНББОУС-д авлагыг ангилж, нэг байгууллага, харилцагчтай хийх тооцоог нэгтгэн бүртгэх гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн нэг байгууллага, харилцагчтай хийх тооцоог нэгтгэн бүртгэж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжилд үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР



Ч.БОЛД